

# Урамшуулалт худалдаа IOI 95

Дэлгүүрийн бараа бүр тодорхой бүхэл тоон үнэтэй. Жишээ нь цэцэг 2 золет, ваар 5з. Худалдан авагчдыг татахын тулд дэлгүүр урамшуулалт худалдаа зарлажээ.

Энэ урамшуулалт худалдаагаар нэг болон түүнээс олон барааг хямдралтай үнээр авах боломжийг санал болгожээ. Жишээ нь:

- 3 цэцгийг 6з-ээр авахын оронд 5з-ээр.
- 2 ваар нэг цэцгийг 12з авахын оронд 10з-ээр.

Уг урамшууллын боломжийг ашиглан хэрэглэгчийн худалдан авсан барааны нийт дүнг хамгийн хямд болгох програм бич. Хэдийгээр нийт дүнг багасгах байсан ч бараа нэмэхийг хориглоно.

Дээр өгөгдсөн үнэ болон урамшууллын хувьд 3 цэцэг 2 ваарны хамгийн хямд үнэ нь 14з. Энэ нь 2 ваар 1 цэцэг 10з, 2 цэцэг 4з нийт 14з болно.

**ПРОГРАМЫН НЭР: shopping**

## ОРОЛТЫН ФОРМАТ

Оролтонд урамшууллауд түүний араас худалдан авалт байна.

1-р мөр:	Урамшуулалт худалдааны төрлийн тоо $s(0 \leq s \leq 99)$ .
2..s+1 мөр:	Мөр бүр санал болгож буй хямдралыг илэрхийлсэн бүхэл тоонууд байна. Эхний тоо $n(1 \leq n \leq 5)$ нь урамшуулалд байгаа барааны нэр төрлийн тоо. Дараагийн $n$ хос тоо $c$ болон $k$ нь барааны тоо ( $1 \leq k \leq 5$ ) бүтээгдэхүүны код ( $1 \leq c \leq 999$ ). Сүүлийн тоо $p(1 \leq p \leq 9999)$ нь хямдарсан үнэ. Энэ үнэ нь бүх бараануудын жирийн үнээс хямд байна.
s+2 мөр:	Барааны нэр төрөл $b(0 \leq b \leq 5)$ .
s+3..s+b+2 мөр:	Дараагийн $b$ мөр бүрт 3 бүхэл тоо $c, k, p$ байна. $C(1 \leq c \leq 999)$ нь барааны код. $K(1 \leq k \leq 5)$ . энэ бараа хэдэн ширхэг байгаа нь. $P(1 \leq p \leq 999)$ . ердийн үнэ. Хамгийн ихдээ $5*5=25$ бараа худалдан авч болно

## ЖИШЭЭ ОРОЛТ(файл shopping.in)

2

1 7 3 5

2 7 1 8 2 10

2

7 3 2

8 2 5

## **ГАРАЛТЫН ФОРМАТ**

Нэг бүхэл тоо байна. Худалдан авалтанд төлөх боломжит хамгийн бага төлбөр.

### **ЖИШЭЭ ГАРАЛТ (file shopping.out)**

14

Орчуулсан : Б.Даваабаяр